

БАТЛАВ: ШУТИС-ИЙН ЭЛСЭЛТИЙН ТӨВ КОМИССЫН ДАРГА Х.ЭНХЖАРГАЛ



“ШУТИС-КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖД 2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны сайдын 2002 оны 333 дугаар тушаалын хавсралт “Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам”-ын 3.3 дахь заалтыг баримтлан 2019-2020 оны хичээлийн жилд “ШУТИС-Коосэн” Технологийн коллежд суралцагч элсүүлэн суралцуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 “ШУТИС-Коосэн” Технологийн Коллежд элсэн суралцахаар хүсэлт гаргагч, элсэлтийн ажлыг удирдан зохион байгуулах элсэлтийн салбар комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.3 Элсэлтийн үйл ажиллагааг хавар, нэмэлтээр намрын улиралд зохион байгуулна.
- 1.4 Элсэлтийн үйл ажиллагааг шударга, ил тод нээлттэйгээр зохион байгуулна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН САЛБАР КОМИССЫГ БАЙГУУЛАХ

- 5.1 Шалгалтын дараах үндсэн зарчмыг баримтлан явуулна.
 - 5.1.1 Сурагчдын сэтгэн бодох чадварыг нээн илрүүлэх боломжтой байх
 - 5.1.2 Шалгалтын даалгавар, шалгуур нь түвшинд тохирсон, үнэн зөв, сурагчдад ойлгомжтой, бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх бололцоотой байх
 - 5.1.3 Шалгалт бодитой, шударга, ил тод байх
 - 5.1.4 Шалгалтын авах хэлбэр нь тодорхой, нийтэд мэдээлэгдсэн байх
- 5.2 Шалгалт зохион байгуулах
 - 5.2.1 Шалгалтын хугацааг 14-21 хоногийн өмнө олон нийтэд зарлах
 - 5.2.2 Бүртгэлийн хураамжийг элсэлтийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагааны зардалд зарцуулна.
- 5.3 Шалгалтын дэг
 - 5.3.1 Элсэлтийн шалгалтыг 2019 оны 06 сарын 15-ны өдөр, нэмэлт элсэлтийн шалгалтыг 8 дугаар сарын 22,23-ны өдрүүдэд авна.
 - 5.3.2 2019 оны 06 сарын 15-н, 8 дугаар сарын 22-ний өдрийн 09⁰⁰ цагт суурь боловсролын математик, физикийн хичээлийн агуулгаар шалгалт (математик-70%, физик -30%)
 - 5.3.3 2019 оны 06 сарын 15-н, 8 дугаар сарын 22-ний өдрийн 14⁰⁰ цагт ярилцлагын шалгалт авна.
 - 5.3.4 Шалгалтын материал боловсруулах багийг томилох, нууцлалыг хадгалан ажиллах үүргийг элсэлтийн салбар комисс томилж хариуцна.
 - 5.3.5 Шалгалтын материалыг шалгалт авах өдрийн 06⁰⁰-08⁰⁰ цагийн хооронд сонгон шалгаруулагчдын тоогоор хувилж олшруулан бэлтгэнэ.

- 5.3.6 Шалгалт авах өдрийн 08⁰⁰-09⁰⁰ цагийн хооронд комиссын гишүүд шалгуулагчдыг бүртгэлийн хуудастай тулган ангиудад хуваарилан оруулж, ассистент багшийг томилно.
- 5.3.7 Ассистент багш шалгалтын материалыг тарааж, шалгалтыг эхлүүлнэ.
- 5.3.8 Шалгалтын хугацаа дуусмагц ассистент багш шалгуулагчийн материалыг шифрлэж, шалгалтын материалыг хурааж авна.
- 5.3.9 Шалгалтын үеийн үйл ажиллагааны талаар ассистент багш тэмдэглэл хөтлөнө. Тэмдэглэлийг шалгалтын материалын хамт салбар комисс хүлээлгэн өгнө.
- 5.3.10 Шалгалтын явцад шалгуулагчаас зөрчил гаргавал шалгалтаас шууд чөлөөлнө.
- 5.4 Шалгалтын материал засах
 - 5.4.1 Шалгалт дууссаны дараа томилогдсон багш нар материалыг засаж дүнг шалгалтын хуудсанд засваргүйгээр тэмдэглэн баталгаажуулж комисст хүлээлгэн өгнө.
 - 5.4.2 Шифрийг тайлж, онооны дарааллаар нь жагсаан шалгуулагчийн оноог шийдвэрлэж олон нийтэд ил тод байрлуулна.

ЗУРГАА. СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ

- 6.1 Шалгалтанд тэнцсэн элсэгчдийн нэрсийг комисс шийдвэрлэн заасан хугацаанд нийтэд мэдээлнэ.
- 6.2 Шалгалтын оноог үндэслэн суралцагч элсүүлнэ.
- 6.3 Элсэлттэй холбоотой аливаа маргааныг элсэлтийн комисс эцэслэн шийдвэрлэнэ.

ДОЛОО. ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ

- 7.1 Сургалтын төлбөрөө бүрэн төлсөн, элсэлтийн комиссын шийдвэрээр шалгалтанд тэнцсэн элсэгчдийг 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 30-ний өдрүүд, 08 дугаар сарын 26-наас 31-ны өдрүүдэд ШУТИС-Коосэн Технологийн коллежийн хичээлийн байранд бүртгэж гэрээ байгуулан, эрхийн бичиг гардуулана.
- 7.2 Суралцах эрх авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчдийг элсэхээс татгалзсан гэж үзээд элсэх эрхийг хүчингүй болсонд тооцно.
- 7.3 Сурагчийн хувийн хэрэг болон, суурь боловсролын гэрчилгээний зөрчилтэй сурагчдыг элсүүлэхгүй болно.